



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/НД

Чингис хот

Коронавируст (Ковид-19) халдварын
эмчилгээний үеийн бэлэн байдлыг хангах ажлын
хүрээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5 "а", 29.1.1 "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын эмчилгээний үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор хүчилтөрөгчийн төхөөрөмж худалдан авахад 8,900,000 (найман сая есөн зуун мянга)-н төгрөгийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт олгосугай.

2. Зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардлагатай зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011951

08 Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын 20 өдрийн 442
дугаар захирамжийн хавсралт

Хүчилтөрөгчийн тоног төхөөрөмжийн зардлын тооцоо

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хүчилтөрөгчийн 40 л-ийн баллон	15	580,000	8,700,000
2	Тээврийн зардал	1	200,000	200,000
3	Нийт үнэ			8,900,000